



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Г Мэс заслын яаралтай тусламж, Г  
үйлчилгээг өөрчлөн зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, Мэс заслын мэргэжлийн салбар зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 12,15-ны өдрийн 3, 4 тоот шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 1-9 дүгээр хорооны хүн амд үзүүлэх мэс заслын яаралтай тусламжийг улсын хэмжээний тусламж, үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй "Номун", 10-19 дүгээр хорооны хүн амд үзүүлэх мэс заслын яаралтай тусламжийг улсын хэмжээний тусламж, үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй "Ачтан" хувийн хэвшлийн эмнэлгүүдээр гэрээний үндсэн дээр 2013 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн гүйцэтгүүлсүгэй.
2. Эмнэлгийн тусламж үзүүлэх гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (С.Туул)-т, иргэдэд яаралтай тусламжийг холбогдох журмын дагуу цаг алдалгүй хүргэхийг Нийслэлийн яаралтай түргэн тусламжийн төв (Ц.Пүрэвдаш)-д үүрэг болгосугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Хатанбаатар/-т даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ